# ХЭНТИЙ АЙМГИЙН
# ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 29 өдөр Дугаар А/57 Баян-Овоо

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21.1.57 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоол, Монгол улсын Хаягжуулалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах тухай” журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21.1.57-д тусгагдсан “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх”, багаж технологийн нарийвчлал хэмжилтийн зөрүү, Хаягжуулалтын тухай хуулийн дагуу хаяг өөрчлөх ажлууд тус тус хэрэгжсэнтэй холбогдуулан хавсралтад дурьдагдсан 2 иргэний хүсэлтийн дагуу газрын хэмжээ, хаяг өөрчлөн 4645$м^2$ газрыг 1 дүгээр хавсралтаар өмчлүүлсүгэй.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2010 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/22 дугаар захирамжийн хавсралтын 32, 2013 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/147 дугаар захирамжийн хавсралтын 6 дахь хэсгийг тус тус хүчингүйд тооцсугай.

3.Холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж гэрчилгээ олгохыг Газрын даамал (Б.Урансайхан)-д даалгасугай.

4.Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Гэрэлмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.МӨНХ-ОД

010000174

Сумын Засаг даргын
2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
А/51 тоот захирамжийн 1 дүгээр хавсралт

| д/д | Өмчлөгчийн | | | | Өмнөх захирамжийн | | | Газрын | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Ургийн овог | Овог | Нэр | Регистрийн дугаар | Огноо | Дугаар | Нэгж талбарын дугаар | Байршил хаяг | Хэмжээ /м2/ | Нэгж талбарын дугаар | Ашиглалтын зориулалт | үнэ /төгрөг/ |
| 0 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| 1 | Улаалзай хөвдүүд | Мөнх | Алимаа | ХИ66041463 | 2010-03-22 | А-22 | 220900078 | Дадал, 4-р баг Баян-Овоо, Яргайт гудамж 105а тоот | 1353 | 2303003199 | Гэр бүлийн хэрэгцээ | 1894200 |
| 2 | Галзууд | Эрдэнэбилэг | Уянга | СЙ87082008 | 2013-10-11 | А-147 | 220900577 | Дадал, 4-р баг Баян-Овоо, Хөндлөн булаг гудамж 1304 тоот | 3292 | 2303002140 | Гэр бүлийн хэрэгцээ | 4608800 |
| | | | | | | | | | 4645 | | | |